

УЛААНБААТАРЫН ТУНХАГЛАЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин 2000 оны арваннэгдүгээр сарын 13-14-ний өдөр Монгол Улсад төрийн айлчлал хийв.

Хоёр улсын Төрийн тэргүүн хоёр талын харилцааны өргөн хүрээтэй асуудал, мөн харилцан сонирхсон олон улсын асуудлаар нухацтай санал солилцлоо. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Төрийн тэргүүн нар Улаанбаатар хотноо уулзаж, яриа хэлэлцээ хийсэн нь хоёр орны уламжлалт найрсаг харилцааг хөгжүүлэхэд чухал үе шат болов.

1.Монгол, Орос хоёр улс 1993 оны нэгдүгээр сарын 20-нд байгуулсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээг тууштай сахин баримталж байгаагаа нотлов. Монгол-Оросын хамтын ажиллагаа, гараагаа эхэлж буй шинэ зуунд НҮБ-ын Дүрмийн заалтууд, олон улсын эрх зүй, шударга ёсны хэм хэмжээний дагуу бүрэн эрхт байдал, эрх тэгш, харилцан ашигтай байх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх зарчимд тулгуурлан, олон арван жилийн туршид бүрэлдэн тогтсон эв найрамдал, сайн хөршийн харилцааны уламжлалын үндсэн дээр янз бүрийн салбарт урагшлан хөгжих ёстой гэдэгт санал нэгтэй байна.

Дэлхий дахинаа олон туйлт бүтцийг тогтоох шаардлагатай гэдэг итгэл үнэмшлийг баримтлан Ази тивд улс хоорондын харилцааг эвсэл, бүлэглэлгүйгээр хөгжүүлэх нь нэн чухал болохыг хоёр Тал цохон тэмдэглээд, аль нэгнийхээ эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа холбоонд оролцохгүй гэдгээ дахин нотолж, нөгөө Талынхаа бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолд харшилсан ямар нэгэн гэрээ хэлэлцээрийг гуравдахь улс оронтой байгуулахгүй байх үүрэг хүлээж байна.

Хоёр талын аль нь ч нөгөө Талын бүрэн эрх, аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулахуйц түрэмгийлэл буюу хүчирхийллийн бусад үйлдэл явуулахад зориулж гуравдахь улсад нутаг дэвсгэрээ хэрхэвч ашиглуулахгүй.

2.Цаашил дээд, өндөр төвшинд тогтмол уулзаж байх, Засгийн газрын байгууллагууд, түүний дотор Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн талаар хамтран ажиллах Монгол-Оросын засгийн газар хоорондын комиссын хүрээнд хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой гэж хоёр Тал үзэж байна.

3.Хоёр Тал бүс нутгийн болон хил орчмын хэлхээ холбоо

хөгжиж байгааг сайшааж, түүнийг цаашид өргөтгөн гүнзгийрүүлэх эрх зүйн үндсийг боловсронгуй болгохын төлөө хүчин чармайлт гаргах болно. Монголын тал Оросын Холбооны Улсын бүс нутгийн бүтцүүд, түүний дотор “Сибирийн Хэлэлцээр” хэмээх бүс хоорондын холбоотой идэвхтэй харилцан ажиллах сонирхолтой байна.

4. Монгол Улс, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нар худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх ихээхэн нөөц бололцоо байгааг цохон тэмдэглээд, хоёр талын худалдааг чөлөөтэй болгон өргөжүүлэх асуудал, түүний дотор төмөр замын тээврийн тариф, гаалийн татвар, бусад хураамжийг хөнгөлөлттэйгээр тогтоох асуудлыг нэгэнт эхэлсэн хэлэлцээний хүрээнд оновчтойгоор авч хэлэлцэн, 2001 онд багтаан дуусгахыг тус тусын орны гүйцэтгэх засаглалын холбогдох байгууллагуудад даалгав.

5. Хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаа нь Зүүн хойт Азид төлөвшин буй бүс нутгийн хамтын ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг хэмээн үзэж, XXI зуунд хандсан бүс нутгийн эрчим хүчний томоохон төслүүд болох хий, газрын тос дамжуулах хоолой, цахилгааны шугамыг барьж байгуулах нь ихээхэн ач холбогдолтой гэж Улаанбаатар, Москвад үзэж байна. Тэдгээр төслийг хэрэгжүүлэхэд эдийн засаг, газар зүйн хүчин зүйлсийг харгалзан Монгол Улс оролцохыг Оросын Тал дэмжиж байна. Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн Комиссын гишүүн орнууд тээврийн салбарт хамтран ажиллах нь чухал чиглэл мөн гэж хоёр Тал үзэж, үүнтэй холбогдуулан Европ болон Ази, Номхон далайн бүс нутгийн хоорондын тээврийн чиглэлийг оновчтой болгох үүднээс Монголын төмөр зам, Сибирийн гол төмөр замыг ашиглахыг сонирхогч талуудад уриалж байна. Тээврийн салбар дахь үндэсний, хоёр талын болон олон улсын төвшиний өнөөгийн механизмыг боловсронгуй болгох шаардлагатайг үндэс болгон Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хоорондын тээврийн асуудлаар үндсэн (ерөнхий) хэлэлцээр байгуулах талаар явагдаж буй гурван талын мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтыг үргэлжлүүлэхээр хоёр Тал тохиров.

6. Монголын эдийн засгийн амин чухал хэсэг болсон “Эрдэнэт”, “Монголпросветмет”, “УБТЗ” зэрэг Монгол-Оросын хамтарсан томоохон үйлдвэрүүдийг шинэчлэн тоноглож, ажлынх нь үр ашгийг дээшлүүлэх нь зүйтэй гэж хоёр Тал үзэв. Тэрчлэн өмчийн янз бүрийн хэвшлийн үндсэн дээр хамтарсан үйлдвэрүүдийг шинээр байгуулах, Монгол Улс, Орос Улс дахь хувьчлалын төслүүдэд хоёр орны аж ахуйн субъектуудыг оролцуулах зэргээр харилцан хөрөнгө оруулалт хийхийг зүйл бүрээр хөхүүлэн дэмжихээр хоёр Тал тохиролцов. Тэд аж үйлдвэрийн салбарт хамтын ажиллагаа хөгжүүлэх

хөтөлбөрийг боловсруулах, Монголын хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд харилцан ашигтай хамтын ажиллагааг сэргээх нь зүйтэй гэж үзэв.

7.Монгол Улсад Орос Улсаас түлш, эрчим хүч нийлүүлэх явдлыг худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны жил бүрийн Протоколын үндсэн дээр тогтвортой болгох үүднээс хамтран ажиллах асуудлыг хоёр Тал авч хэлэлцэв.

8.Байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах явдал өнөөгийн дэлхий ертөнцийн хөгжлийн хандлагатай уялдуулан хоёр орны хамтран ажиллах чухал чиглэл мөн. Хоёр Тал ойн болон хээрийн түймэр, байгалийн гамшиг, техникийн үүдэлтэй гарч болзошгүй сүйрэлтэй тэмцэхэд идэвхтэй харилцан ажиллах болно.

9.Монгол Улс, Орос Улс хоёр ард түмний оюуны болон соёлын уламжлалт нягт хэлхээ холбоог бататган бэхжүүлэх эрмэлзэл төгс байна. Хоёр орны хувь хүмүүс, олон нийтийн болон шинжлэх ухаан, залуучууд, спортын байгууллагуудын хэлхээ холбоог хөхүүлэн дэмжих болно. Оросын дээд сургуулиудад Монголын үндэсний боловсон хүчнийг бэлтгэхэд Оросын Тал хойшид ч дэмжлэг үзүүлж байх болно. Хоёр Тал монгол, орос хэл, бие биенийхээ түүх, соёлын өв уламжлалыг судлахад хамтран ажиллахыг дэмжих болно.

10.Хоёр улсын иргэд харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, виз олгох үйлчилгээг сайжруулах, визийг үнэ төлбөргүй буюу ихээхэн хөнгөлөлттэйгээр олгох хүмүүсийн хүрээг өргөтгөх асуудлыг үргэлжлүүлэн боловсруулах үүргийг холбогдох яам, байгууллагуудад өгөхөөр хоёр Тал тохиролцов.

11.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөл, Оросын Холбооны Улсын Аюулгүй байдлын Зөвлөлийн хоорондын хамтын ажиллагаа бэхжиж байгаад хоёр Тал сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж, хоёр орны аюулгүй байдлын Зөвлөлийн хамтын ажиллагааны Протоколын үндсэн дээр үндэсний болон олон улсын аюулгүй байдлын салбарт цаашид хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа зохицуулж байхын төлөө байна.

12.Хоёр Тал цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааг явуулж, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх салбарт хамтран ажиллахыг сэргээхийн чухлыг цохон тэмдэглэв. Эдгээр салбарын хамтын ажиллагааг олон улсын өмнө хоёр Талын хүлээсэн үүрэгт чанд нийцүүлэн хэрэгжүүлэх болно.

13.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийн шугамыг ялангуяа хил орчмын хүн амын аж ахуйн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй газруудад улам нарийн тодорхой заан тогтоох зорилгоор Улсын хилийг шалгах Монгол-Оросын

хамтарсан комиссоос гүйцэтгэн дуусгаж буй ажил ихээхэн ач холбогдолтой гэж Монгол, Орос хоёр улс үзэж байна.

14.Монгол-Оросын хил дээр зохих дэг журмыг сахиулах, тухайлбал мал хулгайлах үйлдлээс сэргийлэх талаар хоёр улсын хууль хамгаалах, хилийн болон гаалийн байгууллага, тусгай албад уялдуулан зохицуулсан ажиллагааг хамтран явуулж байх болно.

15.Хоёр Тал орчин үеийн гол гол асуудлаар ижил буюу ойролцоо байр суурьтай байгаагаа цохон тэмдэглэж, дэлхий нийтийн үйл хэрэгт хамтын ажиллагаагаа улам өрнүүлж, НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд нягт хамтран ажиллахын төлөө байгаагаа илэрхийлэв. Хоёр Тал Мянганы дээд хэмжээний уулзалт чухал ач холбогдолтой болсныг дурьдан, эл уулзалтын шийдвэр нь НҮБ-ын Дүрмийн цаглашгүй ач холбогдлыг нотлон, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах, мөргөлдөөнийг эв зүйгээр зохицуулахад НҮБ-ын голлох үүрэг, олон улсын эрх зүйн тулгуур зарчмуудыг бэхжүүлэхийн чухлыг тов тодорхой нотолсныг сэтгэл ханамжтай тэмдэглэв. Ард түмэн бүрийн үндэсний онцлог, өвөрмөц байдал, үндэсний соёл, уламжлалын өв баялгийг харгалзсан, сергөлдөөнгүй, тогтвортой, ардчилсан дэг журмыг цогцлон байгуулахын төлөө олон улсын хамтын нийгэмлэгийн нэгдмэл хүчин чармайлтаар л XXI зуунд тулгарах сорилтуудыг даван туулж болох юм гэж хоёр Тал үзэж байна.

16.Энх тайван, аюулгүй байдлыг хангах гол хариуцлага хүлээсэн олон улсын онцгой байгууллага болох НҮБ-ын үйл ажиллагааны үр нөлөө, чадавхийг дээшлүүлэхийг хоёр Тал чухалчлан үзэж байна. Монгол, Орос хоёр улс НҮБ-ыг олон улсын харилцааг хамтын чармайлтаар зохицуулах гол хэрэгсэл болгоход тус дөхөм үзүүлэх болно. Монгол, Орос хоёр улс НҮБ-ын энхийг сахиулах арга ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийг эрмэлзэж, хямралт байдлыг зохицуулахад улс төр-дипломатын арга замыг тэргүүн зэрэгт тавьж байх нь чухал гэж үзэж байгаа бөгөөд олон улсын эрх зүйг дээдлэх зарчимд үнэнч байгаагаа нотолж байна. Үүний хамт зэвсэгт мөргөлдөөн гарахад “байр сууриа илэрхийлдэг уламжлалаас ангижирч, түүнээс урьдчилан сэргийлж дадах” шаардлагатай байгаа тухай НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаас дэвшүүлсэн саналыг хоёр Тал дэмжиж байна. Монгол, Орос хоёр улс Мянганы дээд хэмжээний уулзалтын төгсгөлийн Тунхаглалыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

НҮБ-ыг үндсэн тулгуур зарчмуудыг нь алдагдуулахгүйгээр өнөөгийн бодит байдалд нийцүүлж, бүхий л зангилаа асуудлаар гишүүдийнх нь саналыг аль болохуйц өргөнөөр тусган зөвших үндсэн дээр НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг оновчтойгоор өөрчлөн байгуулахыг хоёр Тал чухалчилж байна.

17.Хоёр Тал глобальчлалын асуудлаар санал солилцов. Глобальчлалын үйл явц нь нийгэм-эдийн засгийн дэвшлийн илүү боломжийг нээж, хүмүүсийн хоорондын харилцаа холбоог өргөтгөхөд нааштайгаар нөлөөлөх эргэлзээгүй сайн талтай бодит үзэгдэл мөн гэж тэд үзэж байна. Үүний сацуу баян чинээлэг болон хөгжиж байгаа орнуудын аж амьдралын төвшингийн ялгаа улам бүр гүнзгийрч байгаагаар ихэвчлэн илэрч буй глобальчлалаас үүдэлтэй шинэ сорилтуудыг гэтлэн давах талаар дэлхийн хамтын нийгэмлэгийн зүгээс шаргуу хүчин чармайлт гаргах шаардлагатай байна.

18.Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх Гэрээний хэрэгжилтийн асуудлаархи 2000 оны Бага хурал дээр цөмийн зэвсэгтэй гүрнүүд уг Гэрээний 6 дугаар зүйлд заасны дагуу цөмийн зэвсгийг хураах талаар тасралтгүй, тууштай хүчин чармайлт гаргах практик алхам хийхээр үүрэг авсныг хоёр Тал талархан сайшааж байна. Үй олноор хөнөөх зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бататгахыг хоёр Тал чухалчилж байгаагаа нотолж, Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх Гэрээ, Цөмийн туршилтыг бүх нийтээр хориглох Гэрээ, Химийн зэвсгийг хориглох Конвенцид бүх улс орон нэгдэн орж, цөмийн зэвсгийн задрах материалын үйлдвэрлэлийг хориглох тухай хэлэлцээ амжилтад хүрнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийлэн, пуужингийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг баримтлахын чухлыг тэмдэглэв.

19.Монгол, Орос хоёр улс стратегийн болон бүс нутгийн тогтвортой байдлыг улам бататгахыг эрмэлзэж байгаа бөгөөд стратегийн тогтвортой байдлын тулгын чулуу, цөмийн зэвсгийг цаашид хорогдуулах үндэс суурь болсон Пуужингийн довтолгооноос хамгаалах тухай 1972 оны Гэрээг сахин бэхжүүлэхийн хамтаар Стратегийн давшилтын зэвсэглэлийн тухай 2 дахь Гэрээг хүчин төгөлдөр болгож, бүрэн хэмжээгээр биелүүлэх, Стратегийн давшилтын зэвсэглэлийн тухай 3 дахь Гэрээг ойрын хугацаанд байгуулах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Пуужингийн довтолгооноос хамгаалах тухай 1972 оны Гэрээг өөрчлүүлэхгүй байх талаар Оросын Холбооны Улсаас гаргаж буй хүч чармайлтыг Монгол Улс дэмжиж байгаа бөгөөд Пуужингийн довтолгооноос хамгаалах үндэсний хэмжээний буюу явцуу эвслийн хүрээний систем байгуулах төлөвлөгөө хэрэгжүүлэх нь олон улсын энх тайван байдалд нэн хор уршигтай бөгөөд эн түрүүнд хөгжиж буй орнуудад хохирол учруулж мэдэх зэвсэглэлээр хөөцөлдөх явдал сэргэхэд хүргэх юм.

20.Монгол Улсын цөмийн зэвсэггүй статустай холбогдуулан тус улсын аюулгүй байдлын баталгааны талаар цөмийн зэвсэгтэй таван гүрний хамтран гаргасан Мэдэгдлийн үзэл санааг Орос Улс тууштай

сахин баримтлахаа нотолж байна. Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах, эл статусыг олон улсын хэмжээнд өргөнөөр хүлээн зөвшөөрүүлэх талаар хүч чармайлт тавьж байгаа Оросын Талд Монголын Тал талархал илэрхийлэв. Төв Азид цөмийн зэвсэггүй бүс байгуулах талаар тус бүс нутгийн орнуудаас гаргаж буй хүчин чармайлтыг хоёр Тал дэмжиж байгаа бөгөөд энэхүү хүчин чармайлт нь Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусын хамт Ази тивд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх дэглэмийг бататгах зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж үзэж байна.

21. Сансрын анхны нислэгийн 40 жилийн ойтой холбогдуулан сансрыг милитаричлахаас урьдчилан сэргийлэх асуудлаар ирэх оны хавар Москва хотноо НҮБ-ын ивээл дор олон улсын бага хурал хуралдуулах, түүнчлэн баяжуулсан уран, цэвэр плутонийг энхийн зориулалттай эрчим хүчний салбарт хэрэглэхгүй байх тухай Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путины дэвшүүлсэн санаачлагыг Монгол Улс дэмжиж байна.

22. Монгол, Орос хоёр улс, Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлаар хүчин чармайлтаа нягт уялдуулан зохицуулахыг чухалчилж байна. Тэд АСЕАН-ы Бүсийн чуулгын үүргийг нааштай үнэлж, ажилд нь зохих хувь нэмэр оруулах болно гэдгээ илэрхийлэв. Ази, Номхон далайн бүс нутагт бий болсон албан ёсны болон албан бус яриа хэлэлцээний бүтцүүдийг бүрэн дэмжиж, тэдгээр нь бүс нутгийн аюулгүй байдал, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг цаашид идэвхжүүлэхэд ач холбогдолтойг цохон тэмдэглэв. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) гишүүн болох гэсэн Монгол Улсын эрмэлзлэлийг Орос Улс дэмжиж байна. Зүүн хойд Азид аюулгүй байдал, хамтын ажиллагааны асуудлыг авч хэлэлцэх улс хоорондын механизм үгүйлэгдэж байгааг хоёр Тал онцлон анхаарч, түүнийг бий болгох үүднээс бүх сувгаар яриа хэлэлцээг идэвхжүүлэхийг чухалчлан үзэв.

Монгол, Орос хоёр улс Пхеньян хотноо 2000 оны зургадугаар сарын 13-15-ны өдөр болсон Солонгос хоорондын дээд хэмжээний уулзалтын үр дүнг сайшааж, Солонгосын хойгт эвлэрч, хамтран ажиллах үйл явц цаашид өрнөнө хэмээн найдаж байгаагаа илэрхийлж байна. Солонгосын хойгт энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах нь Зүүн хойт Ази, нийт Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой байдлын чухал нөхцөл мөн гэж хоёр Тал баттай итгэж байна. Үүнтэй холбогдуулан дэлхийн эл хэсгийн улс орны хооронд харилцан үл итгэлцэх байдал төрүүлж болохуйц аливаа нэг буюу олон талт үйл ажиллагаа явуулахын эсрэг байгаагаа тэд илэрхийлэв.

23. Оросын Тал Олон улсын өргөн хамтын ажиллагааны

нээлттэй байгууллага болох Шанхайн чуулга уулзалтын зорилго, зорилт, үйл ажиллагааны тухай Монголын Талд мэдээлэв. Монголын тал чуулга уулзалтын үйл ажиллагааг сонирхон, ямар нэгэн хэлбэрээр түүнд оролцох боломжийг судалж үзэхээ мэдэгдэв.

24.Бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдал, хөгжил дэвшилд заналхийж болох олон улсын алан хядах үйл ажиллагаа, шашны хэт даврах үндэстний салан тусгаарлах үзэл болох хууль бусаар зэвсэг, хар тамхи наймаалах, хүмүүс хууль бусаар шилжин суурьших зэрэг гэмт хэргийн хэлбэрүүдтэй хамтран тэмцэхийг эрмэлзэж байгаагаа хоёр тал нотолж байна.

25.Энэхүү Тунхаглал аливаа бусад улс буюу бүлэг улс, тэдгээрийн эрхийн эсрэг чиглээгүйг хоёр Тал нотолж байна.

Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин Улаанбаатар хотноо элэгсэг дотно хүлээж авсанд талархлаа илэрхийлж, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийг тааламжтай цагтаа Орос Улсад айлчлахыг урив. Урилгыг талархан хүлээж авав.

Улаанбаатар хот.

2000 оны арваннэгдүгээр сарын 14-ний өдөр.

*Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди
Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин*